

Хичээл эхлэхийн
өмнө сурах бичиг,
дэвтэр, үзгээ бэлдэн
дэлгэцдээ ойртон
суугаарай.



Зөв бичиж сурцгаая.



Дараах харилцан яриаг анхааран уншаад алдаатай үгийн доогуур зурж тэмдэглээрэй.

- Гадаа хаварын улирал болоод сайхан байна аа. Дулаахан.
- Тийм ээ, сайхан байна.
- Маргааш хичээлийн дараа гарж кино үзэх үү?
- Тэгий л даа хамт явий л даа.
- Тэнгист, Хайраа хайрал гэдэг кино гарна гэсэн.
- Бусаддаа дамжуулаарай.
- Маргааш хэдэн цагтай билээ.
- 6 цагтай.
- Ок. Маргааш уулзий.

Яаж зөв болгон бичих вэ?
Юуг анхаарах вэ?

- хавар +ын
- гар + (ж,ч)
- тэг + е
- хайр + л
- бусад + д + аа

Бүтээврийн нийлцийг зөв бичих дүрмээ сэргээн саная.

хавар +ын=
хаврын

гар + ч=
гарч

тэг + е=
тэгье

хайр + л=
хайрла

Гээгдэх эгшгийн
дүрэм

Эгшигт 7
Заримдаг 9 дүрэм

Тусгаарлагч
“Ъ,ь” дүрэм

Үйл үг үүсгэх “л”
дүрэм

~~ЭГ+ЭЭ=ГЭЭ~~
~~Э+ЭЭ=ЭЭ~~
~~ЭГ+Г=ГЭГ~~

7+7=Э 9+7=Э
9+9=Э 7+9=~~Э~~

Эр үг +ъ+я,ё
Эм үг +ь+е
Эгшиг+я,е,ё

7+л (э)
9+(э) л
9+л (э)

намар + ын
хүсэл + ийн
бага +аар
ботго +оор
нөхөд+д+өө
хүүхэд+д+ээ

гар+в бод+л
яв + ж ол + ж
явсан + ыг
бодсон+ыг

яв + я оч + ё
хүс + е хүр + е
хай+я хий+е

НОМ + л
тайлбар + л
нас+л
бяц+л
хувцас+л
холтос+л

Гээгдэх эгшгийн дүрмийн дагуу үгэнд бүтээврийг зөв залгаарай.

~~ЭГ~~+ЭЭ=ГЭЭ

нутаг+ийн
аймаг+ийн
эрдэм+ийн
элдэв+ийг
намар +аас
бодол+оор
хүсэл+ ээс
гарам +аар

~~Э~~+ЭЭ=ЭЭ

бага +аар
элгэ+ ээр
унага+ ыг
ботго+ оор
хурга +ыг
зарга+ аар
хорго+ ын
арга +аар

~~ЭГ~~+Г=ГЭГ

нөхөд +д
бусад + д
сурагчид +д
судлаачид +д

Нөхдөдөө
Бусдадаа

Сурагчдад
Судлаачдад

Үгэнд бүтээврийг залган дүрмийг тайлбарлаарай.

9 + 9

мэдсэн + ийг = мэдсэнийг
үзсэн + ийг = үзсэнийг
ачсан + ыг = ачсаныг
хожсон + ыг = хожсоныг
бодсон + ыг = бодсоныг
очсон + ыг = очсоныг
нисдэг + ийг = нисдэгийг
хаздаг + ийг = хаздагийг
үүсдэг + ийг = үүсдэгийг
хүчдэл + ийг = хүчдэлийг

7 + 9

орчин + ыг =
хэлдэг + ийг =
өгсөн + ийг =
малчин + ыг =
заримдаг + ийн
хөгжил + ийн =
хогшил + ыг =
ширхэг + ийг =
алдар + ын =
сандал + ын =

орчны
хэлдгийг
өгснийг
малчныг
заримдгийг
хөгжлийг
хогшлыг
ширхгийг
алдрыг
сандлыг

Дараах үгсийг дүрэмд харгалзуулан бүлэглээрэй

Эр + ь = я, ё

Эгшиг+я,е,ё

Эм + ь = е

Сонс, сана, мэд, унш, хичээ, хүс, хар, олго, бич, бод, бай, ид, чад, хүргэ, нис, хад, сэх, бос, өмөөр, гар, үз, өг, яв, тэмц

сонсьё
уншъя
харья
бодъё
чадъя
хадъя
босьё
гарья
явья

саная
хичээе
олгоё
байя
хүргэе

мэдье
хүсье
бичье
идье
нисье
сэхье
өмөөрье
үзье
өгье
тэмцье

Дараах үгсийг зөв бичих дүрмээр нь бүлэглээрэй.

усал, ногтол, цэцэглэ, насал, зөвлө, бяцал, ховло, үглэ, хорло, шидэл, дэвтэрлэ, номло, бутал, ачил, мэндэл

7+л= эгшгээ ардаа авна.	9+л= эгшгээ өмнөө авна.	Зөрчих тохиолдол
НОМЛО ХОВЛО ЗӨВЛӨ ЦЭЦЭГЛЭ ҮГЛЭ ХОРЛО ДЭВТЭРЛЭ	УСАЛ БУТАЛ НОГТОЛ НАСАЛ МЭНДЭЛ АЧИЛ БЯЦАЛ ШИДЭЛ	ХУВЦАСЛА ХОЛТОСЛО ХАВТАСЛА ҮНДЭСЛЭ ҮРТЭСЛЭ ХУУДАСЛА БОГТОСЛО УТАСЛА НУХАШЛА ИДЭШЛЭ ХӨДӨСЛӨ

Гэрийн даалгавар

Нэр ба үйлийн нөхцөл,
зөв бичгийн дүрмээ
сэргээн санаарай.

